

Сумын Засаг дарга 2024 оны 03 сарын 13-ны өдрийн 113 тоот албан-бичгийн /...-р хавсралт



2024 оны 1-р улирлын байдлаар

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл					Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр	
Тайлбар: Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	1	2	0	3	4	0	0	0	5	
Тайлбар: Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт			Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, социал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн	
Шивээговь сум	0	0	0	0	8	0	0	0	0	

2023 оны 1-р улиралтай харьцуулсан дүн

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл					Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр	
Тайлбар: Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	1	2	0	3	4	0	0	0	5	
Тайлбар: Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт			Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, социал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн	
Шивээговь сум	0	0	0	0	11	0	0	0	0	

№	Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Санхүүгийн дэмжлэг, тусламж хүссэн	2	25.00	Тэмцээнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх
2	Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох	3	37.50	хөтөлбөр гаргах
3	Тодорхойлолт хүссэн	2	25.00	
4	Цасанд боогдсон замын цасыг түрж, хороо бууцны цасыг цэвэрлэх	1	12.50	
	Нийт	8	100.00	

Сумын Засаг даргын 2024 оны 03-р сарын 25-ны өдрийн 1/155 тоот албан бичгийн 4-р хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2024 ОНЫ 1-Р УЛИРЛЫН МЭДЭЭ

2024.03.25

Шивээговь сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бичгээр, амаар, иргэд олон нийттэй харилцах 70546204 дугаарын утсаар хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллаж байна.

2024 оны 1-р улирлын байдлаар сумын Засаг даргад хандаж ирүүлсэн 8 өргөдлийг хүлээн авч тус өргөдлүүдийг бүрэн шийдвэрлэсэн.

Засаг даргад хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал шийдвэрлэлтийн талаар авсан арга хэмжээ:

Харгалзан дэмжигчээр тогтоох тухай 1 өргөдөлд сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/23 дугаар захирамжаар, Асран хамгаалагчаар тогтоох тухай 2 өргөдөлд сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/35, А/36 дугаар захирамжаар тус тус асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон.

Сумын "Хаялга спорт клуб"-ын өсвөрийн тамирчид Булган аймгийн Булган суманд зохион байгуулагдах "Самбо бөх"-ийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоход унааны зардалд дэмжлэг хүссэн өргөдлийн дагуу Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 350,000 (гурван зуун тавин мянга) төгрөгийг зарцуулж, дэмжлэг үзүүлсэн.

Тэмцээний зардалд дэмжлэг хүссэн Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын Гар бөмбөгийн эмэгтэй багийн тамирчид өөрсдийн хүсэлтээр өргөдлөөсөө татгалзсан.

Хаялганы усны баруун талд Төмс хүнсний ногоо тариалах зориулалтаар газар эзэмшдэг 2 иргэний газар эзэмших хугацаа нь дуусгавар болж байгаа тул тус эзэмшлийн газруудын хугацааг сунгуулахад шаардлагатай тодорхойлолтыг сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 1/127, 1/128 тоот албан бичгүүдээр гаргаж өгсөн.

Сумын хэмжээнд цас их орсноос өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч, хөдөөгийн багийн малчин өрхийн хашаа хороо цасанд дарагдаж, зам харгуй цасанд боогдсонтой холбогдуулан Сумын Онцгой комисс, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон суманд үйл ажиллагаа явуулж байгаа ААН, Компанийг нийгмийн хариуцлагын хүрээнд дайчлан техник хэрэгсэл, хүн хүч ажиллуулан хөдөөгийн багийн малчин өрхүүдийн хороо бууцны цасыг түрж, зам гаргах ажлыг зохион байгуулж ажилласан.

Мөн өргөдөл өгсөн малчны хүсэлтийн дагуу Засаг даргын Тамгын газрын албан хаагчид тус малчин өрхийнд 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр ажиллаж, хороо бууцны хөлдүүсийг цохиж цэвэрлэн улсаас хөнгөлөлттэй болон үнэгүй олгохоор хуваарилагдсан өвс, тэжээлийг ачин хүргэж өгч, 5 кг гурил, 2 шуудай хивэг, үхрийн 4 нэмнээний тусламж үзүүлсэн.

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Б.УУГАНБАЯР

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА

